



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар  
хот

Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын  
үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн  
хэмжээг шинэчлэн батлах тухай

Автотээврийн тухай хуулийн 5.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын  
Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж,  
оношилгооны төлбөрийн хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Автотээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноос хойшхи 2 жилд техникийн  
хяналтын үзлэгт оруулахгүйгээр зөвхөн автотээврийн хэрэгслийн тооллогод  
хамруулж байсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Автотээврийн хэрэгслийг үзлэгт  
оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай” Засгийн газрын  
2004 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд  
тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Д.ГАНБАТ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ  
ОРУУЛАХ ДАВТАМЖ, ОНОШИЛГООНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Тээврийн хэрэгслийн төрөл	Тухайн жилд үзлэгт оруулах давтамж	Нэг удаагийн төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)
Суудлын автомашин	1	20000
Ачааны автомашин	1	30000
Автобус	1	30000
Нийтийн болон жуулчны, ажилчдын, сургуулийн хүүхдийн автобус	2	30000
Такси	2	20000
Трактор, механизм	1	30000
Чиргүүл	1	10000
Мотоцикл	1	10000

Жич: “Автобус” гэдэгт нийтийн болон жуулчин, ажилчид, сургуулийн хүүхэд тээвэрлэдэг автобусаас бусад ажил, үйлчилгээ эрхэлдэг тээврийн хэрэгслийг хамруулж ойлгоно.